

БЗС-ИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

№	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУГАЦАА	ҮР ДҮН, ТАЙЛБАР	ТӨСӨВ
НЭГ. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд				
1	Сургалтад суух, өөрийгөө хөгжүүлэх	2025.06.25	Боловсролын яамны дэргэдэх ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалтад суусан.	-
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль сурталчлах, хэрэгжүүлэх асуудлаар танилцуулга бэлтгэн албан хаагчид болон удирдах ажилтанд сургалт, арга хэмжээ зохион байгуулах, зөвлөмж хүргүүлэх	2025.09.25	Албан хаагч нарт "ЭКО" сургалтын үеэр танилцуулга, мэдээлэл хийсэн. Танилцуулгад: 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зорилго, зорилт, ёс зүйн зарчим, хэм хэмжээ шаардлагын тухай 2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030/-ийн тухай 3. Ёс зүйн хэм хэмжээний тухай МУ-ын засгийн газрын 109 дүгээр тогтоолын тухай агуулга багтсан. Хувь хүний хөгжлийн чиглэлээр "Тэнцвэртэй ажиллаж амьдрахуй" сэдэвт илтгэл хэлэлцүүлэв.	-
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030/-ийг хэрэгжүүлэн ажиллах	2025 он	Шинээр ажилд томилогдсон 6 албан хаагчид "Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн асуудал"-аар танилцуулга мэдээлэл өгсөн. Улмаар ёс зүйн дэд хорооны даргад илтгэх хуудсаар танилцуулсан.	-
4	Байгууллагын нөхцөл байдалд судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийж удирдлагад танилцуулах	2025-11-20	1. БЗС-ийн албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэсэн. 2. Эрсдэлийн үнэлгээг Монгол улсын "Ёс зүйн хороо"-ны 2025.09.26-ны өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас" маягтын дагуу гүйцэтгэсэн. 3. Эрсдэлийн үнэлгээнд нийт 25 албан хаагч хамрагдав. Тус үнэлгээгээр ёс зүйн нөлөөлөлд өртөх эрсдэл байхгүй байсан.	-
ХОЁР. Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах, тайлагнах зорилтын хүрээнд:				
1	Албан тушаалд түр хугацаанд ажилласан албан хаагчид холбогдох журмын дагуу ёс зүйн дүгнэлт гаргах	2025 он	Түр хугацаагаар ажилд томилогдсон албан хаагчдад шаардлагатай тохиолдолд холбогдох журмын дагуу ёс зүйн дүгнэлт гаргах байсан. Гэвч шаардлагатай тохиолдол гараагүй.	-
2	Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргаж тайлагнах	2025 он	Ёс зүйн дэд хороонд сангийн албан хаагчдаас нийт 3 өргөдөл ирүүлсэн. Өргөдлийг МУ-ын ёс зүйн хорооны 2024.08.09-ны өдрийн 13 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу бүртгэл хөтөлсөн. Тус өргөдлийг хэлэлцэж дүгнэлт, шийдвэр гаргасан.	-
ГУРАВ. Дэд хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг тогтворжуулах зорилтын хүрээнд				
1	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх	2025.03.24	Ёс зүйн дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэн ажилласан.	-
2	Ёс зүйн дэд хороог хуралдуулах	2025 он	Ёс зүйн дэд хороо нийт 3 удаа хурал хийж, үйл ажиллагаагаа тогтворжуулахаар ажиллаж байна.	-
3	Дэд хорооны үйл ажиллагааг сурталчлах, тайлагнах, баримт бичгийг архивд хүлээлгэн өгөх	2025.12.31	Дэд хорооны үйл ажиллагаа тайлан, төлөвлөгөө, гэх мэт хадгаламжийн нэгж үүсгэж, архивд хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.	-